

**БАТЛАВ.**

ЗАХИАЛАГЧ  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

С. ЭНХБААТАР  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ГҮЙЦЭТГЭГЧ  
УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ ХХК

Б. ОСОРГАРАВ  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

**АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ**

/ Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ /  
Дугаар № НТАГ-2019/01

Улаанбаатар хот

Нэг талаас **НТАГ** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **Улаанбаатар аудит корпораци ХХК** (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2018 оны 11 сарын 19-ний өдөр энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох гэрээгээр аудит хийлгэх тендерийн баримт бичигт тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ № НТАГ-2019/01-г (цаашид “ажил” гэх) 33 000 000 /Гучин гурван сая/ төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Гэрээний тусгай нөхцөл;
5. Гэрээ нь энд дурдсан зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.
6. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
7. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдлыг арилгах үүрэг, хариуцлагыг хүлээж байна.
8. Захиалагч нь гэрээний дагуу зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдлыг арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хариуцлага хүлээж байна.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
Ц. Бат-Өлзий /Санхүүгийн  
аудитын хэлтсийн дарга/

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 8 дугаар  
хороо Соёлын төв өргөө, "Г"  
корпус, 5 давхар  
Утас/факс: 976-11-320154  
Харилцагч банк - Төрийн сан,  
100200024401

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
Л.Цэвэлмаа/Тамгын газрын дарга/

Монгол улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Юнескогийн  
гудамж-31 Далай тауэр 9-р давхар  
Утас: 70110799, 70110744  
Харилцагч банк: Төрийн банк-  
106000021340

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ж. БАТСАЙХАН /Орж сууц нийтийн аж ахуйн удирдах  
газар ОНӨААТҮГ-ийн дарга/

Хаяг: Чингэлтэй дүүрэг 6-р хороо Бумцэндийн гудамж  
Их тойруу өөрийн байранд

Утас/факс: 70005454; (976-11) 325595  
Харилцагч банк: Төрийн банк 102100001155